

ОЮУТНЫ САЙН ДУРЫН АЖЛЫГ БҮРТГЭХ, БАТАЛГААЖУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг зүйл

1.1 Энэхүү журмаар Отгонтэнгэр их сургуулийн суралцагчдыг хүмүүнлэгийн болон сайн дурын ажилд хамруулах, оролцох, эрх үүргийг тодорхойлох, бүртгэх, оролцоог баталгаажуулж багц цаг тооцох, ажлын туршлагад тооцох үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2 Энэхүү журамд заасан үйл ажиллагааг зохицуулахдаа Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай хууль болон бусад хууль тогтоомжийг баримтална.

1.3 Сайн дурын үйл ажиллагаа нь оюутнуудад эх оронч үзэл, ёс заншил, өв уламжлалаа дээдлэх, эрүүл, чадварлаг, бүтээлч, ёс суртахуунтай, соёлтой иргэн болж төлөвших, иргэний үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, ашгийн төлөө бус нийтэд тустай үйл ажиллагааг өөрсдөө идэвх санаачилгаараа зохион байгуулж, манлайлан оролцох боломжийг олгох зорилготой.

Хоёр. Сайн дурын ажилд баримтлах зарчим

2.1. Сайн дурын ажилд дараах зарчмыг баримтална:

- 2.1.1. сайн дурын, хууль ёсны тэгш эрхийн зарчимд нийцсэн байх;
- 2.1.2. хүний эрхийг эрхэмлэх;
- 2.1.3. хүнлэг, энэрэнгүй байх;
- 2.1.4. хувь хүн, байгууллагын нууцыг чандлан хадгалах;
- 2.1.5. эв нэгдэл, хамтын ажиллагаанд суурилах;
- 2.1.6. хүчирхийллийн бүх хэлбэрийг үл дэмжих;
- 2.1.7. ашгийн төлөө бус, арилжааны шинж чанар агуулаагүй байх;
- 2.1.8. архи, согтууруулах ундаа, мансууруулах бодис, тамхи, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл, хорт буруу зуршил сурталчлахгүй байх;
- 2.1.9. ил тод нээлттэй, уян хатан цагийн хуваарьтай байх;

Гурав. Сайн дурын ажлын чиглэл

3.1. Оюутнуудын сайн дурын ажил нь дараах үндсэн чиглэлийг хамарсан байна:

3.1.1. орчны бохирдол, цаг уурын өөрчлөлт, агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр, хог цэвэрлэх, мод тарих, үржүүлэх, хамгаалах, хог хаягдал цуглуулах, дахин боловсруулах;

3.1.2. Зорилтот бүлэг, олон нийтэд нийтийн соёлыг түгээн дэлгэрүүлэх, амьдрах ухааны чадвар олгох, хариуцлагатай иргэн болж төлөвшихөд дэмжлэг үзүүлэх чиглэлээр, хууль эрх зүйн болон нийгэм, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, нийгмийн оролцоог дээшлүүлэх сургалт, өдөрлөг зохион байгуулах;

3.1.3. өсвөр үеийнхнийг нийгэмшүүлэх, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний асрамж, халамжийн газар, цэцэрлэг, сургуульд тодорхой хугацаагаар ажиллах, туслах, хандивын аян өрнүүлэх;

3.1.4. аливаа хүчирхийллийн хохирогч болсон хүүхэд, өсвөр үеийнхэнд туслах, хууль зүйн зөвлөгөө өгөх, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх;

3.1.5.бүх нийтийн боловсролыг дээшлүүлэх, нийгмийн эрүүл мэндийг дэмжих, эрүүл зан үйл, дадал хэвшил төлөвшүүлэх, уламжлалыг хөгжүүлэх, өв соёлыг хадгалах, сурталчлах ажлууд зохион байгуулах;

3.1.6.нийгмийн хэв журмыг сахиулах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сахих, гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулах;

3.1.7.мэргэжлээ сурталчлах, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад мэргэжил сонголтын зөвлөгөө мэдээлэл, танилцуулга, тэмцээн, уралдаан зохион байгуулах, сургалт, мэтгэлцээн хийх, сургуулиас зохион байгуулж буй тэмцээн, уралдаан, өдөрлөгт сайн дураараа оролцох;

3.1.8.сургуулийн харьяа төв, дугуйлан, клуб, оюутны холбоо, зөвлөлд идэвхтэй ажиллах;

3.1.9.сургуулийн үйл ажиллагаа, хөтөлбөрийн онцлогтой холбогдох төсөл, судалгааны ажил багшийн удирдлага дор гүйцэтгэх, тэнхимд туслах, шинэ оюутнуудад зөвлөх, сургалт, танилцуулга хийх, оюутнуудад зориулсан урлаг, соёл, спортын өдөрлөг, тоглолт хийх, сургуулийн радио хөтлөх, сурталчилгааны ажилд хувь нэмрээ оруулах

3.1.10.сургуулийн анги, танхим цэвэрлэх, дотор гадна тохижилтод туслах

3.1.11.бусад

Дөрөв. Сайн дурын ажилд оролцогчийн эрх, үүрэг

4.1. Сайн дурын ажилд оролцогч нь дараах эрхийг эдэлнэ:

4.1.1.Сайн дурын ажлын чиглэлээ өөрөө сонгох, өөрийн хүсэл, зоригоо илэрхийлэх, хийх эсэх шийдвэрийг гаргах;

4.1.2.Сайн дурын ажил гүйцэтгэсэн тухай лавлагаа мэдээллийг авах, кредит цагаа тооцуулах;

4.1.3.Сайн дурын ажлын талаарх мэдээллийг холбогдох албан тушаалтнаас авах;

4.1.4.аюулгүй байдал, хувийн мэдээллээ хамгаалуулах;

4.1.5.сайн дурын үйл ажиллагаанд оролцсон, үр дүн, гүйцэтгэлээ үнэлүүлж сургуулийн болон бусад тэтгэлэг хөтөлбөрт хамрагдах;

4.1.6.холбогдох хууль болон журамд заасан бусад эрх

4.2. Сайн дурын үйл ажиллагаанд оролцогч нь дараах үүрэгтэй:

4.2.1.Сайн дурын ажил, үүрэг гүйцэтгэхдээ хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын дүрэм, журмыг сахиx;

4.2.2.Өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хангах, бусдад туслах;

4.2.3.Хариуцсан ажлыг заасан хугацаанд нь чанартай гүйцэтгэх;

4.2.4.Сайн дурын үйл ажиллагаанд оролцох явцдаа олж авсан байгууллага болон хувь хүний мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, зөвшөөрөлгүй бусдад түгээхгүй байх, бусдын нэр төрийг хүндэтгэх;

4.2.5.Гүйцэтгэсэн ажлын үр дүн, гүйцэтгэлийг харьяалах хөтөлбөр хариуцсан тэнхим болон ангийн зөвлөх багшид тайлагнах;

4.2.6.Хувь хүний болон нийгмийн ёс зүйн хэм хэмжээг сахиx;

4.2.7.Сайн дурын ажлыг улс төр, шашны үзэл суртлыг сурталчлах, хуулиар хориглосон аливаа асуудлаар ухуулга, сурталчилгаа, нөлөөлөл үзүүлэх зорилгоор гуйвуулан ашиглахгүй байх;

4.2.8.бодит үнэн мэдээллийг нотлох баримтад тулгуурлан олон нийтэд түгээх;

4.2.9.бусдад өгч буй мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг нягтлах, түүнээс үүсэх дагаврыг хариуцах;

4.3. Сайн дурын ажилд дараах зүйлийг хориглоно:

4.3.1.сайн дурын ажлыг хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх, бусдыг хүсээгүй байхад тусламж, дэмжлэг үзүүлэхийг;

4.3.2.мэдээ мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, хувь хүний мэдээллийг зөвшөөрөлгүйгээр бусдад дамжуулах, түгээхийг;

4.3.3.согтууруулах ундаа, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл сурталчлах, бусдад санал болгох, дамжуулахыг;

4.3.4.хүчирхийллийн төрлүүдийг үйлдэх, сурталчлах, садар самуунд бусдыг уруу татах, мэдээллийг нуун дарагдуулахыг;

4.3.5.үндэслэлгүй, нотолгоогүй мэдээллийг олон нийт, нийгэмд санаатайгаар түгээхийг;

Тав. Сайн дурын үйл ажиллагааг бүртгэх, зохион байгуулах, хяналт тавих, баталгаажуулах



5.1. Оюутны сайн дурын ажлын бүртгэл, баталгаажуулалтыг ангийн зөвлөх багш, хөтөлбөр хариуцсан тэнхимтэй хамтран зохион байгуулна.

5.2. Сайн дурын ажилд оролцож буй оюутан ангийн зөвлөх багшаар дамжуулан хөтөлбөр хариуцсан тэнхимд сайн дурын ажлын талаарх мэдээллийг загварын дагуу өгч, бүртгүүлнэ. /хавсралт 2)

5.3. Оюутан гүйцэтгэсэн сайн дурын ажлын тайланг (хавсралт 1) холбогдох шаардлагын дагуу бичиж, нотлох баримтыг хавсарган ангийн зөвлөх багшдаа өгч, багц цаг тооцуулах хүсэлтээ илэрхийлнэ.

5.4. Оюутан сайн дурын ажил гүйцэтгэсэн ажлын тайланд тухайн ажлын зорилго, ач холбогдол, хугацаа, үр дүнг бичиж, гэрэл зураг, видео бичлэг, ажлын төлөвлөгөө, хандив, тусламж авсан бол зарцуулалтын тайланг баримтын хамт хавсаргах болон холбогдох ажлыг удирдсан эрх бүхий албан тушаалтны тодорхойлолт, гарын үсэг, тамга тэмдгээр зэргээр баталгаажуулж нотолно. Ажил нотлогдохгүй тохиолдолд оюутанд холбогдох нотлох баримтаа бүрдүүлэх 14 хоногийн хугацаа өгч болно.

5.5. Оюутны хэрэгжүүлж буй сайн дурын ажлын гүйцэтгэл, үр дүнг холбогдох нотлох баримт бүхий тайланд үндэслэн ангийн зөвлөх багш, ОТИС-ийн сайн дурын үйл ажиллагааны төв хамтран үнэлнэ. Үнэлгээ хийхдээ тайлан, нотлох баримт ирснээс хойш хуанлийн 14 хоногт багтаан зохион байгуулна.

5.6. Үнэлгээ хийгдсэн сайн дурын ажлын бүртгэлийг ОТИС-ийн Сайн дурын үйл ажиллагааны төв бүртгэн, мэдээллийн сан бүрдүүлж, хадгална.

5.7. Хөтөлбөр хариуцсан тэнхим нь сайн дурын ажлын цар хүрээ, гүйцэтгэл, нийгэмд үзүүлэх үр ашиг, нөлөө, гүйцэтгэлийг харгалзан багц цаг тооцох шийдвэрийг гаргаж, дүн үнэлгээг сургалтын нэгдсэн албанд улирал бүрийн сүүлийн 7 хоногт өгч сургалтын системд оруулах хүсэлтийг өгнө.

5.8. Сайн дурын ажилд оролцсон цагийг бодит цагийн нийлбэрээр тооцно. Нэг болон хэд хэдэн сайн дурын ажилд оролцсон байж болно. Нэг удаагийн сайн дурын ажлыг 2-оос доошгүй цаг хийж гүйцэтгэсэн байна.

5.9. Сайн дурын ажил гүйцэтгэсэн тухай лавлагааг дипломын нэмэлт хавсралтаар олгох бөгөөд түүнд оюутны хувийн мэдээлэл болон гүйцэтгэсэн ажлын жагсаалт, гүйцэтгэлийн түвшин, үр дүн, хийсэн хугацаа, тооцсон багц цаг зэрэг мэдээллийг багтаасан байна.

Зургаа. Сайн дурын ажлын дэмжлэг

6.1. Оюутанд сайн дурын ажил хийх, оролцох, санаачлах талаар зорилго, явц, үр дүнг олон нийтэд сурталчлан түгээх, дэлгэрүүлэх ажлыг ОТИС-ийн сайн дурын үйл ажиллагааны хариуцна.

6.2. ОТИС-ийн Оюутны хөдөлмөр эрхлэх төвөөр дамжуулан суралцагчид сургууль дээр сайн дурын ажил гүйцэтгэж болно. Урамшуулалтай байх эсэх асуудлыг талууд тохиролцоно.

6.3. Тэнхим нэгж болон багшийн судалгаа төсөл, хөтөлбөрт туслах чиг үүрэг гүйцэтгэж буй бол удирдаж буй багш шаардлагатай дэмжлэгийг үзүүлж гүйцэтгэсэн ажил, үүрэг, ажилласан хугацааны талаар тодорхойлолтыг тэнхимд бичиж өгнө

6.4. Оюутанд сайн дурын ажил хийх, оролцох, санаачлах талаар мэдээлэл, зорилго, ач холбогдлыг таниулах, ажлын явц, үр дүнг олон нийтэд сурталчлан түгээх, дэлгэрүүлэх чиглэлээрх сургалтыг ОТИС-ийн сайн дурын төв жил бүр зохион байгуулна.

6.5. Сайн дурын ажил гүйцэтгэж буй оюутнуудад ОТИС-ийн Сайн дурын үйл ажиллагааны төв мэргэжил, арга зүйгээр дэмжин ажиллана.

Хавсралт 1. Сайн дурын ажлын тайлан бичих загвар



Ажил гүйцэтгэсэн газар:

Ажилласан өдөр, цаг:

Удирдсан, чиглүүлсэн байгууллага, албан тушаалтан:

Үйл ажиллагааны чиглэл:

Ажлын зорилго, ач холбогдол:

Өөрийн оролцоо, гүйцэтгэсэн үүрэг:

Үйл ажиллагааны хамрах хүрээ:

Гүйцэтгэсэн, оролцсон ажлаас сурсан мэдлэг, өөртөө төлөвшүүлсэн чадвар, хандлага:

Ажлын үр дүн:

Оролцогч талууд:

Өөрийн оролцоо, ажлын гүйцэтгэл, үр дүнг 100 хүртэл оноогоор үнэлэх:

Тайлан бичсэн: Нэр, гарын үсэг

Хянасан:

Сайн дурын үйл ажиллагааг удирдсан холбогдох албан тушаалтны нэр, гарын үсэг, тамга тэмдэг, албан тушаалт

Огноо

ОЮУТНЫ САЙН ДУРЫН АЖЛЫН БҮРТГЭЛ

Энэхүү мэдээлэл нь сайн дурын ажлын бүртгэлийг үүсгэх, сайн дурын ажлыг үнэлэхэд ашиглагдана.

Оюутны хувийн мэдээлэл:	
Ургийн овог	
Эцэг/эхийн нэр	
Өөрийн нэр	
Регистрийн дугаар	
Нас	Хүйс
Хаяг	
Утасны дугаар 1	
Утасны дугаар 2 яаралтай үед холбоо барих, хэн болох	
Цахим шуудан	
Аль сувгаар холбогдохыг илүүд үзэх	☐ Утас ☐ Цахим шуудан ☐ Утас, цахим шуудан
Сайн дурын ажлыг хэрхэн олсон	☐ Сургууль ☐ Байгууллагаас санал болгосон ☐ Өөрөө олсон
Сайн дурын ажил нь цалин, хөлстэй эсэх	☐ Тийм ☐ Үгүй
Сайн дурын ажлыг тооцох журамтай танилцсан эсэх:	☐ Тийм ☐ Үгүй
Сайн дурын ажлын мэдээлэл	
Сайн дурын ажлын чиглэл, төрөл	
Хийгдэх ажил	
Хэрэгцээ шаардлага	
Эхлэх, дуусах огноо	
Үргэлжлэх хугацаа	
Хүний тоо	
Оролцох талууд, бусад байгууллагууд	
Хүлээгдэж буй үр дүн	
Хариуцах /удирдах, зохион байгуулах, үр дүнг тайлагнах/ ажилтны нэр, албан тушаал, утасны дугаар, цахим шуудангийн хаяг	
Гарын үсэг зурснаар дээрх мэдээлэл үнэн зөв болохыг баталж байна. Гарын үсэг: Нэр: Огноо:	